


АХБ

# ЖЕНДЭРИЙН ШАЛГУУР ЖАГСААЛТ

(Gender Checklist)



БОЛОВСРОЛ

## Агуулга

Жендэрийн шалгуур жагсаалтын зорилго	
Жендэр яагаад боловсролын төсөлд чухал вэ?	1
Гол асуудлууд	2
Төслийн хүрээн дэхь гол асуудлууд болон үйл ажиллагааны үе шатууд	5
Боловсролын төслийн жендэрийн асуудлууд	6
Суурь болон бага боловсрол дахь жендэрийн асуудлууд	10
Бүрэн дунд боловсрол дахь жендэрийн асуудлууд	12
Мэргэжлийн боловсрол дахь жендэрийн асуудлууд	13
Албан бус боловсрол сургалт дахь жендэрийн асуудлууд	14
Боловсрол дахь жендэрийн стратегиуд	17
Хавсралт	
1: Төсөл хэрэгжүүлэх явц	20
2: Жендэрийн Мэргэжилтний ажил үүргийн хуваарь	21
Эх сурвалжуудын түүвэр	22

## Товчлол

ХБГО	Хөгжиж Буй Гишүүн Орон
ЖХ	Жендэр ба Хөгжил
АНУ	Анхдагч Нийгмийн Үнэлгээ
ХҮ	Хяналт ба Үнэлгээ
ТББ	Төрийн Бус Байгууллагууд
ТБТТ	Төсөлд Бэлтгэх Техникийн Туслалцаа
АУХ	Ажил Үүргийн Хуваарь

Энэхүү баримт бичгийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор монгол хэлнээ хөрвүүлсэн боловч англи хэл нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны албан ёсны хэл тул зөвхөн англи хэл дээрхи эх хувийг нь албан ёсных хэмээн үзнэ. Иймд иш татахдаа англи эхийг ашиглана уу. АХБ орчуулгын үнэн зөв эсэх талаар баталгаа өгөхгүй бөгөөд эх хувиас утга нь гажсан тохиолдолд аливаа хариуцлага хүлээхгүй болно.

## Гарын авлагын зорилго

Жендэрийн шалгуур жагсаалт нь АХБ-ны ажилтан болон зөвлөхүүдэд АХБ-ын Жендэр болон Хөгжлийн бодлого, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тус нэмэр болох зорилготой (АХБ-ын 1998 оны Жендэр болон Хөгжлийн Бодлого үзнэ үү).

Энэхүү гарын авлага нь жендэрийн гол асуудлуудыг боловсролын салбарын төсөл/хөтөлбөрүүдэд оруулах, төслийн бүх шатанд удирдамж болгон, жендэрийн мэдрэмжтэй стратеги, бүтэц, бүрэлдэхүүн хэсгүүд болон үзүүлэлтүүдийг боловсруулах, жендэрийн асуудлуудад холбоотой арга хэмжээ авахад тусална.

АХБ-ын ажилтнууд нь жендэрийн шалгуур жагсаалтыг ашиглан Төсөл бэлтгэх Техник Туслалцааны (ТБТТ) үед шатанд нийгмийн суурь үнэлгээнд жендэрийн асуудлыг оруулан тодорхойлох ёстой.

ТБТТ-ийн үед зөвлөхүүд илүү нарийвчилсан нийгмийн дүн шинжилгээ хийхдээ мөн ашиглах нь зүйтэй. Гэхдээ эдгээр асуудлууд бүх төслүүдэд хамаатай бус. Тухайн агуулгад нийцсэн тодорхой асуултуудыг

банкны ажилтан болон зөвлөхүүд зөвлөлдөн сонгон авна. Жендэрийн мэдрэмжтэй АНУ хийж бэлтгэх удирдамжийг болон нийгмийн дүн шинжилгээг АХБ-ны төслийн портфолиогоос кейс болгон багтаасан бөгөөд үүгээрээ боловсролын төсөлд жендэрийн асуудлыг оруулсан бодит жишээг танилцуулахыг зорисон.

Төслийн бэлтгэл ажлын үед хяналтын хуудсыг АХБ-ны «Төсөлд Нийгмийн Олон Талт асуудлыг оруулах нь» гарын авлага (1994), «Үр Ашигтай Хяналт Үнэлгээний Удирдамж болон Хөгжил дэх Эмэгтэйчүүдийн асуудлууд» цуврал нийтлэлүүдтэй цуг ашиглаж болно. Энэ номын төгсгөлд цаашид ашиглаж болох эх сурвалжуудын жагсаалт байгаа.

Хяналтын хуудсыг Сюзан Вендт болон Ширийн Латийф нар зөвлөх Пенелоп Шоэфилийн бэлтгэлажилдээр үндэслэн хийв. Мэри Анн Асико эх бэлтгэлийг хийж, Жун Дела Круз эцсийн байдлаар хянан тохиолдуулав. Маривик Гуиллермо хэвлэлтэнд туслалцаа үзүүлэв.

## БОЛОВСРОЛЫН ТӨСЛҮҮДЭД ЖЕНДЭР ЯАГААД ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Боловсрол нь хүний эрх бөгөөд тэгш эрх, хөгжил болон энх тайвныг бий болгоход зайлшгүй шаардлагатай хэрэгсэл мөн. Үл ялгаварлан гадуурхах боловсролын тогтолцоо эрэгтэй эмэгтэй хоёуланд нь ашиг тусаа өгдөг бөгөөд тэдний хоорондын харилцааг адил тэгш болгодог.

Гарч буй нийгмийн өөрчлөлтүүдэд хувь нэмэр оруулахын тулд эмэгтэйчүүд боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдсан байх ёстой. Эмэгтэйчүүд бичиг үсэгт тайлагдах нь илүү чанартай эрүүл мэнд, амин тэжээл болон боловсролыг бий болгох, мөн түүнчлэн нийгэмд бодит өөрчлөлт, хувь нэмрээ бүрэн оруулах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг дээшлүүлдэг.

Охид эмэгтэйчүүдийн албан ба албан бус боловсрол болон сургалтанд хөрөнгө оруулах нь тогтвортой хөгжил болон эдийн засгийн өсөлтийг бий болгох хамгийн шилдэг арга гэдэг нь нотлогдсон. Охид эмэгтэйчүүдийн боловсрол нь нийгэм эдийн засгийн онцгой өндөр үр ашгийг авчирдаг.

Хүн бүр суурь боловсрол болон бусад шаардлагатай үйлчилгээг хүртэх боломжтой байх ёстой. Ийм хүртээмж байхгүй тохиолдолд ялангуяа ядуучууд болон тэдний хүүхдүүд, өөрсдийн эдийн засгийн байдлаа сайжруулах эсвэл бүрэн утгаар нь нийгэмд оролцох боломж их багатай болно.

## ГОЛ АСУУДЛУУД

Боловсрол нь эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах гол хөшүүрэг юм. Боловсролын салбарт жендэрийн анализ хийх анхны алхам нь хөгжиж буй гишүүн орнуудын /ХГО/ тухайн салбар дахь жендэрийн дараах үзүүлэлтүүдийг хамарна. Үүнд:

Боловсролын шат бүрт эмэгтэйчүүдийн оролцоо хэр байгаа вэ?

- ➔ Боловсролын янз бүрийн шатанд охид-хөвгүүд болон эмэгтэйчүүд- эрэгтэйчүүдийн оролцооны хоорондын ялгаа ямар байна?
- ➔ Жендэрийн оролцооны хувь бүс нутгийн дагуу өөр байна уу?
- ➔ Боловсролын хүртээмжинд нөлөөлөх нийгмийн болон эдийн засгийн хүчин зүйлс юу вэ?

Энэ урьдчилсан дүн шинжилгээг үндэслэн төслийн ЖХ-ийн нөөц боломжийг дүгнэх болно. Хамгийн өндөр ЖХ-ийн нөөц боломжтой боловсролын төслүүд нь ХБГО-уудын боловсролын тогтолцоонд дахь жендэрийн тэгш бус байдал, бүс нутгийн онцлог зэргийг г хамарсан байх ёстой. Жишээ нь: аж үйлдвэрлэл хөгжиж буй орнууд, эсвэл орчин үеийн хотжилтын төслүүдэд эмэгтэйчүүд бүрэн дунд боловсрол болон дээд боловсрол олгох түвшин ялангуяа техникийн болон эмэгтэйчүүдийн уламжлалт бус мэргэжлийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх зорилготой төслүүд нь илүү дүн илүүтэй байж болох юм.

ХБГО-ууд эсвэл тэдгээрийн дотор голдуу хөдөөний хүн ам олонтой орнуудын эмэгтэйчүүдэд охидын бага боловсрол, хөдөө орон нутаг болон цөөн хүн амтай суурин газруудад албан бус боловсрол, бичиг үсэг заах ангиуд болон зайны сургалтууд явуулбал илүүтэйгээр үр ашигаа өгдөг.

Бага болон дунд түвшиний сургуулийн төслүүд нь дараахи асуудлуудыг авч үзнэ.

**Нийгмийн бүрэн  
гишүүн байхын тулд  
эмэгтэйчүүд болон  
ядуус тэгш эрхтэйгээр  
боловсролоос хүртэх  
эрхтэй байх ёстой.**

## Боловсролын хүртээмж болон эмэгтэйчүүдийн оролцооны түвшин

Охид/ эмэгтэйчүүдийн оролцооны түвшин доогуур байгаа нөхцөлд ТБТТ-ны урьдчилсан бодит байдлын судалгаагаар шалтгаануудыг гаргаж ирж, төслийг боловсруулах явцад гарч ирсэн бэрхшээлүүдийг даван туулах арга замуудыг тодорхойлох ёстой.

## Хичээлийн хөтөлбөр болон сурах бичгийг сайжруулах нь

Сурах бичиг болон хөтөлбөрийг сайжруулах зорилготой төслүүд нь жендэрийн хэвшмэл ойлголтуудыг сурах бичгийн агуулга, дүрс зургаас арилгахад чиглэгдэх ёстой.

## Эмэгтэй багш нар бэлтгэх нь

Боловсролын салбарын ЖХ-ын асуудлууд нь охид эмэгтэйчүүдийг зөвхөн оюутан төдийгүй мөн боловсролын мэргэшсэн багш бэлтгэхийг анхааран авч үздэг.

Багш нар нь хөвгүүд, охидууд болон тэдний орчин тойрныхонд чухал үлгэр жишээ болдогв Ялангуяа шийдвэр гаргах түвшинд болон өндөр албан тушаал хашдаг багш мэргэжилтэй олон тооны эмэгтэйчүүд нь бусад эмэгтэйчүүд, охид болон залуу эмэгтэйчүүдэд үлгэр дууриал болж, эмэгтэйчүүдэд хандах нийгмийн хандлагад эерэгээр нөлөөлөх боломжтой.

## Нийгмийн хандлагууд

Эмэгтэйчүүдийн боловсролын хүртээмжийг сайжруулахын тулд боловсрол дахь нийгмийн хандлага ба эрэгтэй эмэгтэй хүмүүсийн боловсролд хандах үнэлэмж зэрэгт дүн шинжилгээ хийх нь нэн чухал.

## Хайрцаг 1

## Охидын суурь боловсролын төсөл (Лаос улс 1998)

Уг төслийн урт хугацааны зорилт нь олон эмэгтэйчүүдийн боловсролын түвшнийг ахиулах замаар тэднийг нийгэм, улс төрийн хөгжилд хамруулахад оршино. Ойрын хугацаанд тавьж буй төслийн зорилт нь охидуудын анхан шатны боловсролд хамрагдах боломжийг нь нэмэгдүүлэхэд оршино. Төслийн арга зүй нь уян хатан буюу төслийн үр дүн, амжилтыг төслийн явц дунд нь байнга үнэлэн дүгнэж, хийсэн дүгнэлтүүдээ дараа дараагийн үйл ажиллагаанууддаа нэвтрүүлж ажиллана. Төсөл нь төрийн үйлчилгээний гадуур орхигдсон болон үйлчилгээ бага хүртдэг хүн ам цөөнтэй үндэсний цөөнхүүдэд зориулж тодорхой сургалтанд хамрагдсан багш нар сургалт явуулж, сургалтын материалиар хангана. Түүнчлэн ядуу гэр бүлүүдийн боловсролд зарцуулах зардлыг нь багасгах зорилгоор тохиромжтой арга хэмжээнүүдийг авна.

Уг төсөл нь сургуульд элсэх болон тогтвортой суралцах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн удирдлагад иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжиж тосгоны зөвлөл, Лаос Эмэгтэйчүүдийн Байгууллага болон ТББ-уудыг оролцуулна. Төсөл нь мөн олон нийтийн оролцоог дэмжих чиглэлээр доорх үйл ажиллагаануудыг явуулна:

1. Охидуудаа сургуульд явуулж тэднийг тогтвортой суралцах боломжоор хангах

2. Сургууль барих ажиллагаанд дэмжлэг үзүүлэх  
3. Сурах бичгийн хүртээмжийг хангахад туслах  
4. Сургууль болон тосгон, орон нутгийн үйл ажиллагаануудад оролцох  
5. Боловсролд зарцуулагдах өрхийн зардлыг багасгахад туслах тусламжийн хэлбэр, хэрэгцээг тодорхойлох.

Сургалтын амжилт нь ихэнх тохиолдолд заах болон сурах материалын хүртээмжээс хамаардаг. Төсөл нь одоогийн шилдэг сургалтын арга барил, практикийг эргэн харах,

**КЕЙС  
СУДАЛГАА**

мөн шаардлагатай хэсэгт нэмэлт материал болон багшийн гарын авлагыг боловсруулах, шалгах, хэвлэх болон түгээхийг дэмжинэ. Энэ хэсэг нь оюутнуудын ялангуяа охидуудын сургалтын хэрэгцээг хангах зорилгоор сургалтын хөтөлбөр болон заах материалуудыг эргэн харна. Эцэст нь төсөл нь багш бэлтгэх үйл явцад анхаарал тавина. Төсөл нь эмэгтэй болон үндэсний цөөнхи багш нар болон оюутны тоо, түүний дотор эмэгтэй оюутаны тоог тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах, эрүүл мэндийн даатгал олгох, ном, боловсролын материал болон хөнжил, шумуулнаас хамгаалах тор болон гар чийдэн зэрэг хэрэгслэлээр хангах замаар нэмэхийг зорьж байна. Сургалтаа дуусгасны дараа төгсөгчид төсөл хэрэгжиж байгаа дүүргийнхээ үндэсний цөөнхийн сургуулиудад багшлах болно.

Боловсролд эмэгтэйчүүд оролцоог тэгш хангахын эсрэг соёлын ямар хэм хэмжээ, практик оршиж байна вэ?

## Төслийн хүрээний гол асуудлууд ба авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Боловсролын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд байдал ямар түвшинд байна вэ?

## Боловсролын төсөл дэхь жендэрийн асуудлууд.

### Гол асуултууд:

→ Төслийн зорилтууд ядуу охид, эмэгтэйчүүдийн хэрэгцээнд тулгуурласан уу?

→ Төслийн зорилтуудыг тодорхойлоход эмэгтэйчүүд хэрхэн оролцсон бэ?

→ Элсэлт дэхь хүйсийн ялгааны шалтгаан юунд байна? Ялгаа нь элсэлтийн бодлого, практик эсвэл охидууд амьдрахад тохиромжгүй дотуур байр байна уу?

Эмэгтэйчүүдийг сургуульд элсэхэд элсэлтийн төлбөр саад болж байна уу? Боловсролын ямар түвшинд? Гэр сургууль хол байгаа нь сургууль руугаа хүрэх аюулгүй байдалтай холбоотой юу?

→ Эрэгтэй, эмэгтэйчүүдийг тусад нь ялгавартай авч үздэг соёлын хэм хэмжээг төсөлд хэрхэн тусгасан бэ? Охид /эмэгтэйчүүд болох хөвгүүд/ эрэгтэйчүүд аль алинд нь тусдаа, чанартай дэд бүтэц шаардлагатай юу? Зорилтот хүн амын

сургууль эмэгтэй багштай юу? Дээрх зүйлсийн санхүүгийн болон улс төрийн ач холбогдол?

→ Гэр бүл дотор боловсролд зарцуулах зардлын талаар хэн шийдвэр гаргаж байна?

→ Охид, хөвгүүдийн боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг яаж тооцдог вэ? Охидод боловсрол олгосноор гэр бүл сайн хөрөнгө

оруулалт хийлээ гэж үздэг юу? Хүү нь ахмад настай эцэг эхээ асран сувилана гэсэн ойлголт байна уу? Ингэснээр хөвгүүдийн боловсролд илүү анхаарч байна уу?

→ Охид боловсролтой байх нь гэрлэхэд саадтай гэж үздэг үү? Эсвэл сайн уу? Боловсрол нь сүйт бүсгүйн инж гэх мэт ёс заншилд хэрхэн нөлөөлөх вэ?

→ Охидын боловсрол нь эцэг эхийнхээ төлөвлөгөөтэй зөрчилдөнө гэж үздэг үү?

→ Эмэгтэй хүүхдийн хөдөлмөр нь эрэгтэй хүүхэдтэй харьцуулбал гэр орондилүү хэрэгцээтэй гэж үздэг үү?

→ Сургууль болон коллежд хүйсээр ялгаварлах явдал нь нийгмийн итгэл үнэмшлээс хамаарч байна уу? (охид/эмэгтэйчүүд зөвхөн эмэгтэй багшаар заалгах шаардлагатай эсэх)?

→ Эмэгтэй оюутнууд нь эрэгтэй оюутнуудтай адил хичээл заалгаж байна уу эсвэл хөтөлбөр нь эрэгтэй эмэгтэй гэж ялгаатай байна уу? Охидууд зөвхөн тодорхой хэдэн хичээл үзэх ёстой гэсэн үзэл байна уу? Уг хичээлүүд нь зорилгот хүн амын бүлгийн сургуулиудад заагдаж байна уу?

→ Жендэрийн хэвшсэн ойлголтыг сурах бичиг болон бусад боловсролын хэвлэл мэдээлэл сурталчилж байна уу (хүүхэд тэвэрсэн эмэгтэйчүүдийн зураг болон газар тариалангийн багаж барьсан эрэгтэйчүүд гэх мэт)?

→ Төсөлд эмэгтэй багш нарын сургалтыг оруулсан уу?

→ Мэргэжил эзэмших чиглэлээр зөвлөгөө өгөх

хэлбэрээр дамжуулан эмэгтэйчүүд бүх төрлийн сургалтанд хамрагдахад дэмжлэг авч байна уу?

→ Эмэгтэйчүүд сургуулийн менежмент болон эцэг эх багш нарын холбоонд орж байна уу? Боловсролын Яам дах шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн хувь?

→ Эмэгтэйчүүдийг боловсролын төслийн бүх түвшинд оролцуулах асуудал дээр гүйцэтгэх агентлаг ямар ажил хийсэн бэ?

**Төслийн зорилтууд нь эмэгтэйчүүдийн хэрэгцээтэй шууд уялдаж байна уу?**

Эмэгтэйчүүд боловсролын төслөөс үр шим хүртэх явдлыг баталгаажуулах үүднээс хяналт болон жендэрийн үр нөлөө, ашгийн дүн шинжилгээ хийхэд тусгай санхүүжилт буюу бусад нөөц шаардлагатай болох эсэх?

→ АХБ-ны тухайн улсын ЖХ-ын стратегийн зорилт эсвэл ХБГО-ны ЖХ-ын зорилтуудтай нийцэхүйц жендэрийн асуудлыг төсөлд оруулсан эсэх?

→ ХҮ-ний тогтолцоо нь эмэгтэйчүүд төслөөс хэрхэн үр ашиг хүртэж байгааг дүгнэж байна уу?

### ЗӨВЛӨМЖ

#### Сургуулийн

#### удирдлага,

#### багшийн

#### сургуулиудад

#### эмэгтэйчүүдийн

#### тоог нэмэх

#### талаар шуурхай

#### арга хэмжээ авах

### ЗӨВЛӨМЖ

#### Багшлах

#### боловсон

#### хүчнийг бэлтгэх

#### хөтөлбөрүүдэд

#### эмэгтэй багш

#### нарын тоог

#### нэмэх

**Гол стратегиуд:**

- Охид, эмэгтэйчүүдийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн зорилго, стратеги болон төлөвлөгөөг гаргахад ХГО-д туслах.
- Т ө с л и й н б о л о в с р у л а л а т, хэрэгжилт, хяналт болон үнэлгээнд олон нийтийг оролцуулах нэмэгдүүлэх стратеги боловсруулах. Төслийн төлөвлөгөө, боловсруулалтанд с а н х ү ү ж ү ү л э г ч байгууллагууд, сурагчид, багш нар, орон нутгийн хүмүүс, орон нутгийн засгийн газар болон ТББ-уудыг оролцуулах.
- Орон нутгийн оролцоо, ялангуяа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд ТББ-ыг хамруулах.
- Б о л о в с р о л ы н тогтолцооны түвшинд охид/ эмэгтэйчүүдийн дунд элсэлт, сургууль завсардалт, элсэлтийн тоо цөөрөх, төгсөлтөнд нөлөөлж буй эдийн засаг, нийгмийн нөхцөл шалтгааныг судлах, эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн болон хэрэгцээг гаргасан тоо баримтыг цуглуулах, мөн эмэгтэйчүүдийг ажил эрхлэлтэнд саад болж буй зүйлс.
- Соёлын хандлагад нөлөөлөхийн тулд нийгмийн маркетингийн хандлагыг ашиглаж охид эмэгтэйчүүдийн боловсролын ач холбогдлыг сурталчлах.

Охид / эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлаж байгаа хүчин зүйлсийг багасгах чиглэлээр арга хэмжээ авах. Жишээ нь:

- Эмэгтэйчүүдийн элсэлт доогуур байдаг боловсролын түвшинд тэтгэлэг/ стипенд олгож эмэгтэйчүүдийг дэмжих.
- Хөдөө орон нутагт охидуудад зориулж тусгай сургууль нээх.
- Охидуудад зориулж тэтгэлэг өгөх чиглэлээр хөрөнгө хувиарлах.
- Охидод боловсрол олгох шаардлагатай талаар орон нутагт ойлгуулахад зориулж орон нутгийн нөөц бололцоог дайчилж, мөн төрийн ажилтнуудыг сургах.
- Сургуулийн цагийг уян хатан байлгах талаар харгалзах.
- Охидын дотуур байранд зориулж мөнгө хувиарлах.

**ЗӨВЛӨМЖ**

Охидын  
боловсролын ач  
холбогдлыг орн  
нутгийн хүмүүст  
ойлгуулах

- Мэргэжлийн сургууль болон дээд боловсрол эзэмшихэд урьдчилсан бэлтгэл болгож шинжлэх ухаан болон техникийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд бага сургуулийн түвшинд өөрчлөлт оруулах эсвэл хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах шаардлагатай.
- Төслөөсзохионбайгуулж байгаа сургалт болон тэтгэлэг авах боломжийг эрэгтэй эмэгтэйчүүдэд адил тэгш хангах.
- Зорилтот хүн амын сургуульд эмэгтэй багш нар олноор ажиллуулах. Орон нутгийнхны оролцоо болон бусад арга хэлбэрээр эмэгтэй багш нарын аюулгүй байдлыг хангах.
- Хэрэв багшлах орон тоо гарсан бол орон нутгаас багш сонгон ажиллуулах
- Шаардлагатай бол эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх стратегийг боловсруулахад гүйцэтгэх агентлагт хэрэгцээтэй санхүүг хувиарлах. Энэ зорилгоор жендэрийн зөвлөхүүдийг ажиллуулах.
- Боловсон хүчинг илгээх, хувиарлах, хөдөө орон нутагт багш нарын тогтвор сууршилыг хангах.
- Бага/ дунд боловсролыг багш нарт бүх сургалтанд нь жендэрийг тусгай хичээл болгон оруулах.

Эмэгтэйчүүдийн оролцоог сургуулийн менежмент, багш бэлтгэх сургуулиудад бий болгох үүднээс тусгай тогтолцоог бий болгох. Жишээ нь:

- Доод хязгаар тогтоох. /квот/
- Төсөлд шийдвэр гаргах болон удирдах ажилтан, үлгэр жишээ хүмүүсийг оруулах (хөтөлбөрийн захирал, сургуулийн захирал г.м.)
- Сургуулийн менежмент, удирдлагад орон нутгийн оролцоог өргөжүүлэх зорилгоор ТББ-уудыг хамруулах.

**ЗӨВЛӨМЖ**

Бие даан  
боловсрол олж  
авсан хүмүүс  
ялангуяа  
эмэгтэйчүүдийг  
мэргэжлийн  
сургууль болон  
дээд боловсрол  
эзэмшихэд  
туслах үүднээс  
боловсролын  
хөтөлбөрүүдийг  
үргэлжлүүлэн  
явуулах, сунгах  
боломжийг  
бүрдүүлэх

## Суурь болон бага боловсрол дахь жендэрийн асуудлууд

### Гол асуултууд:

#### ЗӨВЛӨМЖ

#### Эмэгтэй багш

#### нарын тоог

#### нэмэх үүднээс

#### эмэгтэй нэр

#### дэвшигчдэд

#### тавих

#### боловсролын

#### үзүүлэлт

#### шаардлагыг

#### багасгах

- Охидууд, ялангуяа ядуу охидын боловсролын болон сургалтанд хамрагдах боломж байна уу?
- Нийгмийн бүлгүүдэд охидыг сургуульд явахад ямар саад учирдаг вэ?
- Охид хөвгүүдийн хоорондын тэгш бус оролцооны цаана нь оршиж буй шалтгаанууд юу вэ?
- Охидын сургуульд суралцах боломж, хүртээмжийг сайжруулахад ямар байр шаардлагатай вэ? /тусгай дотуур байр, ариун цэврийн өрөө, эмэгтэйчүүдийн сургуульд суралцах эрмэлзлийг төрүүлэх үүднээс тусгай санхүүгийн урамшуулал /
- Хэрхэн охид хөвгүүдийн сургууль завсардалтын түвшинг бууруулах вэ?
- Эмэгтэй багш ажиллаж байна уу?
- Сургалтын чанар, багшийн заах арга ямар байна?
- Эмэгтэйчүүд сургуулийн удирдлага менежментэд оролцож байна уу?
- Бусад салбар хоорондын хүчин зүйлс эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлж байна уу? Үүнийг өөрчлөхийн тулд зөвлөгөө болон эрүүл мэндийн үйлчилгээний хэсгүүд шаардлагатай юу?
- Төслийн сургалт эсвэл тэтгэлэг авах боломж охид/ эмэгтэйчүүд болон хөвгүүд/ эрэгтэйчүүдэд адил тэгш байна уу?

Сургалтын явуулж буй байршил нь эмэгтэй эрэгтэй хоёуланд нь адил хүртээмжтэй юу? Сургуулийн байрыг охид/ эмэгтэйчүүдэд илүү хүртээмжтэй болгохын тулд хэрхэн сайжруулах вэ?

### Гол стратегиуд:

- Охид хөвгүүд аль алинд нь тохиромжтой сургуулийн байршил сонгох. Сургууль нь охидод шаардлагатай байр төхөөрөмжтэй юу? (охид/эмэгтэйчүүдийн аюулгүй дотуур байр, сургалтын байр, тусгай, хаалттай ариун цэврийн өрөөнүүд)
- Хэрэв охидын элсэлт бага байвал тоог нэмэх үүднээс төслийг боловсруулах даа хөшүүрэг урамшууллыг харгалзаж үзэх. (жишээ нь: тэтгэлэг, үнэгүй ном ба сургуулийн дүрэмт хувцас)
- Төсөлд эмэгтэйчүүдийг тусгаарладаг соёлын хэм хэмжээг харгалзан үзэж эмэгтэй багш нарыг бэлтгэх, охидын боловсролын ач холбогдлыг орон нутгийнханд мэдрүүлэх болон бусад арга хэмжээг авах.
- Ядуу охид/ эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх стратегийг тусгайлан хөгжүүлэхэд санхүүжилт хувиарлах.
- Э м э г т э й ч ү ү д и й н оролцоог хязгаарлаж буй асуудлуудыг хөндөж арга хэмжээнүүдийг төсөлд тусгах (Жишээг Хайрцаг 1-ээс харна уу)
- Төсөлд багшийн заах аргын чанар болоод сургуулийн орчны талаар тусгах.
- Нийгмийн хэрэгцээ шаардлага болон эрхэлж буй аж ахуйг харгалзан орон нутагт тохирсон хөтөлбөрийг боловсруулах.
- Хөтөлбөр, сурах бичиг болон боловсролын хэвлэх материалд жендэрийн хэвшсэн ойлголтыг улам гүнзгийрүүлж буй зураг дүрсийг эргэн харах, өрчлөх. Жишээ нь: Сурах бичигт шинжлэх ухаан, математик, эзэр тариалан болон газар мэнд, боловсролын холбогдолтой дүрс, зураг, бичгийг эмэгтэй эрэгтэй аль алинд нь хамаатуулах тал дээр эргэн харах.
- Сургуулийн менежментэд эмэгтэйчүүдийг оролцуулах үүднээс тусгай тогтолцоог боловсруулах. (Жишээг Хайрцаг 4-өөс хар)
- Төслийн хэрэгжилтэнд ТББ-ыг оролцуулахыг харгалзан үзэх.
- Шаардлагатай бол хяналт болон жендэрийн дүншинжилгээнд зориулж охид, эмэгтэйчүүд төслөөс үр ашиг хүртэж байгааг баталгаажуулах үүднээс санхүүг хувиарлах.

#### ЗӨВЛӨМЖ

#### Орон нутгийн

#### хэрэгцээ

#### шаардалага,

#### түүний

#### үйлдвэрлэлд

#### нийцсэн

#### хөтөлбөрийг

#### боловсруулах

#### ЗӨВЛӨМЖ

#### Чадавхийг

#### бэхжүүлэх

#### сургалтаар

#### дамжуулан

#### эмэгтэйчүүдийн

#### орлого олох

#### боложийг

#### өргөжүүлэх

## Бүрэн дунд боловсрол дахь жендэрийн асуудал

### ЗӨВЛӨМЖ

#### Бага болон

#### бүрэн дунд

#### сургуулийн багш

#### нарт жедэрийн

#### сургалт явуулах

### Гол асуултууд:

- Охидод зориулсан хөтөлбөрийн талаарх мэдээлэл талаар олон нийтэд өргөнөөр мэдээлэгдсэн эсэх? Хөдөө орон нутагт бүрэн дунд боловсролыг санал болгож байна уу?
- Бүрэн дунд боловсрол дахь охидын элсэлтэнд тулгарч буй ямар бэрхшээлүүд байна вэ?
- Бүрэн дунд боловсролын төвүүдэд эмэгтэйчүүдэд зориулсан хангалттай байр, төхөөрөмж байна уу? (Жишээ нь: аюулгүй эмэгтэйчүүдийн дотуур байр, хүйсээр нь ялгаварладаг соёлын хэм хэмжээтэй газруудад эмэгтэйчүүдэд зориулсан сургалтын тусгай байр төхөөрөмж бий эсэх)
- Энэ түвшинд эмэгтэй багш нарын тоо хангалттай байна уу?

### Гол стратегиуд:

- Охид хөвгүүд мэргэжилээ сонгох шатанд мэргэжлийн зөвлөлгөө өгөх, сонголт хийхэд нь туслах үүднээс үлгэр жишээ эмэгтэйчүүдээр талаар ярих.
- Эмэгтэйчүүдийн оролцоонд саад тотгор болж буй хязгаарлалтуудыг авч үзэх, тусгай арга хэмжээг төсөлд тусгах. (Жишээг Хайрцаг 1-т дурьдсан)
- Мэргэжлийн сургууль болон дээд боловсрол олгоход бэлтгэх зориулалтаар анхан шатны бүрэн дунд эсвэл түвшин дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг (сунгах, боловсролыг үргэлжлүүлэх гэх мэт) судлах. Ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд мөн сургалтанд хамрагдаж чадахгүй байгаа хүмүүст чиглүүлэх
- Шинжлэх ухааны болон техникийн салбарт эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих үүднээс доод хязгаар тогтоох /квотын систем/ эсвэл тэтгэлэг олгох.
- Сургуулиа бүрэн дүүргэхэд нь дэмжих охидуудыг дотуур байраар хангах
- Олон эмэгтэйчүүдийг багш болоход нь дэмжих. Тусгай арга хэмжээ болон эмэгтэйчүүдэд ээлтэй ажлын орчинг бий болгох замаар боловсролтой эмэгтэйчүүдийг багшлахыг хөхүүлэн дэмжих
- Эмэгтэйчүүдийг сургуулийн удирдлага менежмент, багш бэлтгэх байгууллагуудад ажиллуулах г.м. тусгай механизмыг бий болгох. (Жишээ нь: хайрцаг 4-өөс харна уу)

### Сургуулийн төсөл нь:

- Эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаа шалтгааныг судлах
- Сурах бичгээс жендэрийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгах.
- Эмэгтэй багш нарыг олноор бэлтгэх
- Эмэгтэйчүүдийн боловсролын талаарх нийгмийн хандлагыг өөрчлөх тус тус шаардлагатай

### Хайрцаг 2

#### Бангладеш, бүрэн дунд боловсролын хөгжлийн төсөл, 1993

АХБ-наас санхүүжүүлсэн төсөл нь зориулж нэмэлт сургалт явуулсан. Өрхүүдэд эмэгтэй хүүхдээ сургуульд Дээрхи арга хэмжээнүүд болон охидын тогтмол явуулахад нь дэмжлэг боловсролын ач холбогдолын талаархи үзүүлж сургалтын тэтгэлэг хэлбэрээр тусгай ойлголт дээшилсэний үр урамшуулалын арга хэмжээ авсан. Уг санаачлагыг дүнд бүрэн дунд боловсролд охидын элсэх тоо дэмжиж шинэ сургуулиудыг байгуулсан. дүнд гэрлэлтийн нас хойшлогдож, Жендэрын хэвшмэл ойлголтыг арилгах эрүүл мэндийн талаар ойлголт нь зорилгоор хөтөлбөрийг шинэчилж, сайжирсан. эргэж харж, мөн эмэгтэй багш нарт

### КЕЙС СУДАЛГАА

## Дээд боловсрол дахь жендэрийн асуудал

### Гол асуултууд:

- Дээд боловсролын салбар хичээлүүдэд эмэгтэй оюутны тоо хэрхэн хувиарлагдсан байна?
- Дээд боловсрол эзэмшихэд эмэгтэйчүүдэд ямар саад бэрхшээлүүд учирдаг вэ?
- Дээд боловсролын сургуулиудад эмэгтэйчүүдэд зориулсан шаардлагатай байр төхөөрөмж байна уу? (аюулгүй эмэгтэйчүүдэд дотуур байр, эмэгтэйчүүдийн суралцах байр зэрэг)
- Энэ түвшинд эмэгтэй багш нар байгаа юу?

### Гол стратегиуд:

- Эмэгтэй оюутнуудад зориулж дээд боловсролын түвшинд квот тогтоох.
- Тэтгэлэг болон бусад урамшуулалыг санал болгосноор эмэгтэйчүүдэд гадаадад суралцуулах явдлыг дэмжих доод хязгаар квот тогтоох.
- Математик, байгалийн шинжлэх ухааны хичээлүүдийг эмэгтэй оюутнууд сонгон, суралцах талаар арга хэмжээ болон бусад хөтөлбөрийг зохион байгуулах.
- Боловсон хүчний бодлогыг хөгжүүлж ажлын байрны тодорхой хувийг эмэгтэй нэр дэвшигчдэд хувиарлах.
- Боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт эмэгтэйчүүдийн тоог хадгалахын тулд шаардлагатай дэмжлэг үзүүлэх (тохирсон сургалтын байр, тэтгэлэг, санхүүжилт г.м.)
- Жендэрийн мэдрэмжтэй зөвлөгөөг хэрхэн өгөх талаар зөвлөхүүдэд сургалт явуулах.

Албан бус сургалтын боломжуудын талаар ядуу эмэгтэйчүүд мэдээлэл хэрхэн авдаг, тэдний оролцоог хэрхэн дэмждэг вэ?

## Хайрцаг 3

## Бангладеш, Албан бус боловсролын төсөл, 1995.

Засгийн газраас бичиг үсэггүй явдлыг устгах бодлоо явуулж байгаа боловч олон тооны хүүхдүүд, өсвөр насныхан болон насанд хүрэгчид боловсролгүй хэвээр байна. Хэрэв Бангладеш улсад «хоёр дахь боломж» боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй бол 2000 он гэхэд 15-24 насны бичиг үсэггүй хүний тоо 20 сая болно. Ядуурлыг улам гүнзгийрүүлж байгаа гол хүчин зүйл бол бичиг үсэггүй болон амьдралын боломж муутай байх

**КЕЙС  
СУДАЛГАА**

явдал юм. Төслийн зорилт нь ядуурлыг багасгаж эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулахад оршино. Төсөл нь залуучуудын ялангуяа эмэгтэйчүүдийн албан бус боловсролын хөтөлбөрийг өргөжүүлэх болон сайжруулах, байгууллагыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэ нь дунд, удаан хугацааны байж болох бөгөөд тогтвортой үйл ажиллагааг баталгаажуулахад оршино. Энэ нь суралцагчдыг тодорхойлох, тэднийг

### Албан бус боловсрол сургалтан дахь жендэрийн асуудлууд

#### Гол асуултууд:

- Зорилтот хүн амын бүлгүүдийн дотор эмэгтэйчүүд сургалтанд хамрагдах хангалттай цагтай юу?
- Гэрийн ажилтай эсвэл ажил эрхэлдэг эмэгтэйчүүдэд сургалтанд хамрагдах цагийн боломж үүнийг хэрхэн зохион байгуулдаг уу? Эмэгтэйчүүд өөрсдөө сургалтын хөтөлбөрийг сонгоход тусалдаг уу?
- Соёлын хэм хэмжээ ба эмэгтэйчүүдийн нүүн аялах боломжийг харгалзан орон нутагт явагдаж буй сургалтууд нь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд хүртээмжтэй байна уу? Эмэгтэйчүүдийн оролцоог хангахын тулд хүүхдийг асран саатуулах газар шаардлагатай байна уу?
- Албан бус боловсрол/ сургалтын талаарх мэдээллийг ялангуяа ядуу эмэгтэйчүүд хэрхэн авч болох талаар ямар нэгэн төлөвлөгөө байна уу? Төслийн талаар
- эмэгтэйчүүдэд мэдээлэл өгч, тэдний оролцоог дэмжих тал дээр сүлжээг бий болгож ашиглаж байна уу?
- Өөрийн бие даасан орлогогүй эмэгтэйчүүд дээрх сургалтын зардлыг төлж чадах уу? Эмэгтэйчүүдийн оролцоог хангах үүднээс тэтгэлэгт хөтөлбөр, тохирсон орон байрны нөхцөл болон бусад тусгай хэрэгцээ шаардлагатай эсэх?
- Сургалт нь эмэгтэйчүүдийн үйлдвэрлэх нөөц боломж, ийг бий болгох, тэдний зах зээлийн чадавхийг бий болгох болон орлого олох боломжийг сайжруулах уу? Энэ сургалтаар эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, хүн ам, бусад асуудлыг хөндөж байна уу?
- Төслийн мониторинг үнэлгээгээр эмэгтэйчүүдэд үзүүлж буй нөлөөг авч үзэж байгаа юу?

орон сууцаар хангах, багшийг элсүүлэх зэрэг тогтсон орон нутгийн практикийг ашиглаж, нутгийн хүмүүстэй хамтран менежментийн хороог байгуулах зэрэг ажлуудыг хийхэд дөхөмтэй. Мөн орон нутгийн хүмүүс хөтөлбөрийг эргэн харах, бичиг үсэг тайлагдсаны дараах хөгжил болон цаашдын сургалтын материалыг бэлтгэхэд оролцоно. Энэ төсөлд эмэгтэйчүүдийн боловсролын тусгай стратегиуд чухал хэсгийг эзэлдэг. Албан бус боловсролын төвүүд нь хэрэглэгчдэд ойрхон байрлаж, эмэгтэй

багш нарыг эмэгтэйчүүдийн бүлгүүдэд заалгах, сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулах, жендэрийн мэдрэмжтэй удирдлагын мэдээллийн системийг боловсруулах, мөн туршилтын үйл ажиллагаа болон нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Төслийн гол хэрэгжүүлэгчид нь ТББ-ууд. Төсөл нь орон нутгийн бүлгүүдийн оролцоог эрхэмлэнэ. Олон талын эх сурвалжын тусламжтайгаар эмэгтэйчүүдийн боловсролд учирч буй гол бэрхшээлүүдийг гүнзгий судалж хөгжлийн стратегиудыг боловсруулна.

#### Гол стратегиуд:

- Төслийн сургалтанд эрэгтэй эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах.
- Ядуу эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх, стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт санхүүжилтыг гүйцэтгэх агентлагт шаардлагатай эсэхийг үнэлэх.
- Сургалтын хөтөлбөрт эрүүл мэнд, байгаль орчин болон бусад асуудлыг оруулах боломжийг үнэлэх.
- Эмэгтэйчүүдийн орлого олох чиглэлээр сургалт, чадавхи олгох сургалт зохион байгуулах.
- Мониторинг үнэлгээ нь төслийн үр дүнг нийгмийн бүлгүүдэд хэрхэн нөлөөлснийг үнэлэх, жендэрээр ялгавартай судлах.

**ЗӨВЛӨМЖ**

[Эмэгтэйчүүдийн сургалтанд хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын болон бусад тэтгэлээр дэмжих](#)

Боловсрол дахь жендэрийн тэгш эрхийг сургуулийн хүртээмжийг сайжруулах, чанартай багшлах боловсон хүчин бэлтгэх, бага зардал, хичээлийн хөтөлбөр, олон нийтийн оролцоо болон боловсролын удирдлагын төвлөрлийг бууруулах зэрэг арга хэмжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

## Хайрцаг 4

## Пакистаны Бага сургуулийн охидын төсөл, 1996

Хүйсээр нь тусгаарлах соёлын зан үйл нь охидыг сургуульд элсэх явдлыг ихэнхи тохиолдолд хязгаарлаж байдаг. Эцэг эхчүүд өөрсдийн охидоо эрэгтэй сурагчидтай хамт суралцаж эрэгтэй багш нараар хичээл заалгах дээр эргэлзэнгүй ханддаг. Пакистанд энэ асуудлыг шийдэх үүднээс хөдөө орон нутагт охидод зориулан загвар сургуулиуд бий бологон хөгжүүлэхэд уг төсөл тусалж байгаа. Сургууль бүр таван анги танхимтай бөгөөд бага сургуулийн анги бүрт нэг ноогдож байгаа. Сургууль бүр төслийн хүрээнд бэлтгэгдсэн таван эмэгтэй багштай бөгөөд тэдний тохитой амьдрах нөхцөлийг хангаж сургуультай ойрхон орон байр гаргасан. Загвар сургуулиудын зарим нь урьд өмнө иймэрхүү чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд зарим нэгэн өөрчлөлт хийсэн. Бусад нь шинэ. АХБ-ын санхүүжилттэй уг төслийн хүрээнд 800 загвар сургуулийг байгуулсан. Хоёрдугаар төсөл нь өргөжиж 1000 нэгж зөвлөлд загвар сургуулиудыг нэмж байгуулах зорилготой. Сургууль байгуулах гэдэг нь ажлын зөвхөн нэг хэсэг. Цаашилбал доорх асуудлуудыг шийдэх шаардлагатай. Үүнд: Охидыг яаж сургуульд оруулах, мөн тэднийг хэрхэн тогтвортой сургах вэ? Пакистанд барилгыг сургуулийн зориулалтаар хэрхэн өөрчлөх вэ? Мөн шийдэх ёстой бусад асуудлууд: Охидоо сургуульд сургах талаар эцэг эхчүүдийг хэрхэн дэмжиж урамшуулах вэ? Эмэгтэй багш нарыг тогтвор суурьшилтай хэрхэн ажилуулах вэ? Сурагчид болон багш нарын дунд хичээл таслах явдлыг хэрхэн гаргуулахгүй байх

**КЕЙС  
СУДАЛГАА**

вэ? Материаллаг бааз дэд бүтцийг бүрдүүлэхээс гадна бусад арга хэмжээг анхаарах нь зүйтэй. Жишээ нь сургууль бүрэн утгаараа тогтвортой үйл ажиллагаагаа явуулах, үүнд багш сурагч нар тогтмол хичээлдээ ирэх, мөн боловсролын чанар нь өндөр түвшинд байх гэх мэт. Дээр дурьдсан зүйлсийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх аргыг сонгосон. Загвар сургуулиудын менежментэд орон нутгийн оролцоог хангах үүднээс ТББ-ын тусламжтайгаар эрэгтэй эмэгтэйчүүдийн тусгай хороонуудыг байгуулсан. Тухайн хороонууд нь эцэг эхчүүдийн охидуудаа сургуульд тогтмол явуулах, эмэгтэй багш нарын аюулгүй байдлыг хангах болон багшийн орон тоонд ажиллах орон нутгийн хүмүүсийг сонгох зэрэгт үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой. Мөн төслийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр боловсон хүчнийг сургалтанд хамруулж, хөдөө орон нутагт багш нарын хүртээмжийн дээшлүүлж, хичээл тасрах, шилжих явдлыг багасгахад оршино. Төслийн ачаар анх удаа гэр бүлийн гишүүд охидоо тогтвортой сургуульдаа явж буй үр дүн гарч байна. Цаг хугацаа өнгөрөхөд эцэг эхчүүд бичиг үсэг тайлагдсан охидуудтай байхын давуу талыг олж харах болно гэж найдаж байна. Магадгүй охидууд нь өөрсдийн болон гэр бүлийнхээ сайн сайхан, эдийн засгийн хөгжилтөнд хувь нэмрээ оруулах үед үүнийг сайн мэдэрч олж харна. Засгийн газар, гэр бүлүүд охидод боловсрол олгохын үнэ цэнийг мэдрэх үед уламжлалт саад бэрхшээлүүд алга болно.

## Боловсрол дахь жендэрийн стратегиуд

### Сургуулийг илүү хүртээмжтэй болгох

Сургууль гэр хоорондын зай ойрхон байхад ялангуяа охидыг сургуульд суралцахад сайнаар нөлөөлнө. Сургууль нь оршин суугаа газартай ойрхон байх явдал нь охидын аюулгүй байдал болон нийгмийн нэр хүндэд эрсдэл багатай. Тусгай байраар хангах, хаалттай ариун цэврийн өрөө олноор нь байгуулах дээр анхаарлаа хандуулах.

### Багш нарын заах аргын чанарыг сайжруулах, эмэгтэй багш нарын тоог нэмэх.

Эмэгтэй багш нарийн тоонд доод хязгаар буюу квот тогтоох. Цөөн тооны эмэгтэйчүүд багшлах шаардлагыг хангасан байдаг тул орон нутгаас багш нарыг авч ажилуулах нь нэн чухал. Хичээл, сургалтуудыг орон нутагт ойрхон зохион байгуулах нь эмэгтэйчүүдийг олноор татахад чухал үүрэгтэй. Учир нь эмэгтэйчүүдийг хол явж болохгүй гэсэн зарим соёлын хязгаарлалтууд, орон байрны хүртээмж эсвэл гэр бүлийн хариуцлага зэргээс шалтгаалан эмэгтэйчүүд багшлах ажлыг сонгодоггүй. Мөн багш бэлтгэх хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах.

## Эцэг эхээс гарах зардлыг багасгах.

Олон нийгэмд охидыг сургуульд явуулах нь хөвгүүдээс илүү зардал гардаг гэж үздэг. Тэдний тооцоогоор охидуудын боловсролын шууд (жишээ сургуулийн төлбөр, сурах бичиг, /цаад зардлууд/ сургуулийн дүрэмт хувцас, хэрэгслэл ) болон боломж олгох зардал (охидын гэр орны ажил, газар тариалангын үүрэг хариуцлага) зардалууд нь хөвгүүдийн зардлаас илүү байдаг байна.

Сургуулийн төлбөр, сурах бичиг, дүрэмт хувцас болон дотуур байр зэрэг зарим зардлыг тэтгэлэгт хөтөлбөрөөр нөхөж болно. Боллоцооны зардлыг стипенд багасгах боломжтой. (Бүрэн дунд боловсролыг хөгжүүлэх төсөл, Банладеш 1993, Хайрцаг 2-ыг харна уу.)

## Хичээлийн хөтөлбөр боловсруулах

Боловсролыг газар тариалан болон бүтээлч үйл ажиллагаатай холбосон, эрүүл мэнд болон амин тэжээлийн асуудлыг сөхсөн, тухайн үндэстэн ястны хэл дээр, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэгдсэн, амьдралд ойр хөтөлбөрийг боловсруулах нь охидуудыг сурах хүсэл эрмэлзлийг төрүүлж, төсөл үр дүнтэй болно.

## Оролцооны аргаар дамжуулан эцэг эх болон олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх.

Охидын боловсролд хандах хандлагыг өөрчлөх шаардлага бий. Олон нийтийн нөлөө бүхий гишүүд болон шашны тэргүүнүүдийн дэмжлэгтэйгээр эрэгтэй, эмэгтэй хүүхдийг сургуульд явуулахыг дэмжинэ. Охидын боловсролд төлөвлөлт, менежмент, шийдвэр гаргах болон сурталчлан таниулах үйл ажиллагаанд эцэг эхчүүд болон олон нийтэд нааштай нөлөө үзүүлдэг.

## Удирдлагын төвлөрөлийг сааруулах.

Сургуулийн удирдлага менежментийн үйл ажиллагаа нь үндэсний, орон нутгийн дүүргийн түвшнээс дүүрэг багийн түвшинд шилжсэн тохиолдолд боловсролын бусад тогтолцоогоор дамжуулан эмэгтэй эрэгтэй хүмүүсийг удирдах зөвлөлд адил тэгш оруулах нь чухал.

Багш нар бол чухал үлгэр дууриал болдог. Эмэгтэй багш нарын тоо хангалттай юу?

## Суралцагчдын жендэрийн онцлогтой холбоотой хэрэгцээг хангасан тогтолцоог бий болгох.

Сайн хөтөлбөр боловсруулахын тулд охид хөвгүүдийн боловсролын үйл явц болон ололтонд саад хязгаарлалт болж буй соёлын болон бусад асуудлыг судалж үзэх нь зүйтэй. Гэртээ ажилладаг охидууд болон зах дээр ажилладаг хөвгүүдэд сургуулийг илүү хүртээмжтэй болгох үүднээс ядуусын хороололд хагас өдрийн бага сургууль, хагас цагийн бага сургууль болон бага сургууль гэх мэт сургуулийн уян хатан хэлбэрүүдийг бий болгох.

## Боловсрол хүртээх тогтолцоог боловсруулах.

Бүх нийтийн суурь боловсролыг олгохдоо дан ганц албан боловсролоор олгоно. Хөвгүүд ба охид, эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн боловсрол олгох асуудлыг янз бүрийн сувгуудаар дамжуулдаг. Мөн албан боловсролын хэлбэрүүд ч ач холбогдолтой.

## Хавсралт 1

## ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

## Гол асуудлууд

## Авах арга хэмжээ:

## Хэрэгжүүлэгч Агентлаг (ХА)

→ Хэрэгжүүлэгч агентлагийн жендэрийн мэдрэмж

→ Өндөр түвшиний албан тушаалтан /төслийн ажилтнуудад жендэр ба оролцооны сургалтыг зохион байгуулах

→ Бүх түвшний боловсон хүчинд жендэрийн сургалт явуулахыг дэмжих

→ Эмэгтэйчүүдийн асуудлаарх үндэсний механизмаас дэмжлэг авах

→ Төслийн боловсон хүчин, төсөв

→ Эмэгтэй төслийн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, жендэрийн сургалтанд зориулж төсөвлөх талаар ХА-ын дэмжлэгийг авах

→ Төслийн менежмент

→ Төслийн удирдах зөвлөлд эмэгтэйчүүдийн төлөөлөл байхыг шаардах

## Хяналт ба Үнэлгээ (ХҮ)

→ ХҮ-г явуулахад шаардлагатай ажлуудыг хийх: (1) төслийн ажилтнуудаар дотоод ХҮ хийх, (2) Шаардлагатай бол ТББ-ууд /зөвлөхүүдээр ХҮ-г хийлгэх, (3) Төслийн ашиг хүртэгч эрэгтэй эмэгтэйчүүдийг оролцуулсан ХҮ

→ Бүх холбогдох үзүүлэлтүүдийг жендэрээр ялган задлах

## Судлах эргэн хянах

→ Нийгмийн бүлгүүдэд үзүүлсэн төслийн нөлөөний үнэлгээг оруулах, жендэрээр нь задлах

## Хавсралт 2

## ЖЕНДЭРИЙН МЭРГЭЖИЛТНИЙ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

## Төсөл бэлтгэх техникийн туслалцааны (ТБТТ) үеийн нийгмийн үнэлгээ (НҮ)

## ТБТТ-ийн Нийгмийн Анализ болон боловсруулалт

→ Боловсролын салбар дахь ядуурал болон жендэрийн асуудлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх. Ядуурлыг бууруулахад үр дүнтэй арга хэрэгслийг боловсролын салбарт санал болгох.

→ Зорилтот хүн амын бүлгийг тодорхойлох. Мэдээллийг жендэрийн ялгавартай боловсруулах, үүнд боловсролын статус, элсэн суралцах байдал, завсардалт болон төгссөн байдлыг насны ялгаатай байдлаар харгалзан үзэх.

→ Хүн амын цөөнхийн бүлгүүдийн доторхи ялгааг гаргах. Тус бүлгүүдийн дотор охид/хөвгүүд болон эмэгтэй/эрэгтэйчүүдийн хооронд боловсролын хүртээмжийн тал дээр ялгаа байгаа эсэх

→ Төслийн зорилтот хүн амын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох. Жишээ нь охид/эмэгтэйчүүд болон хөвгүүд/эрэгтэйчүүд боловсрол/сургалтанд хамрагдахын тулд тусгай орон байр, нөхцөл шаардлагатай байгаа эсэх. Мөн ялгаатай байдал нь төсөлд хэрхэн нөлөөлөх.

→ Дотоод нөөцийг тодорхойлох. Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд төсөлд хэрхэн оролцож байгаа тодруулах. Тэдний сэдэл, мэдлэг, чадавхи болон зохион байгуулах эх үүсвэрүүд. Мөн тухайн төсөл тэдний соёл болон нийгэмд хэрхэн таарч нийцэж байгааг вэ гэдгийг харгалзах. Боловсролын төсөлд охид/эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлаж буй хүчин зүйлсийг тодорхойлох (сургуулийн төлбөр, гэр бүл дэх жендэрийн үүрэг хариуцлага г.м.)

→ Төсөлд хувь нэмрээ оруулж болох эмэгтэйчүүд болон Жендэр ба Хөгжлийг (ЖХ) чиглэлээр ажилладаг төрийн болон ТББ, агентлагыг тодорхойлох

→ Төслийг боловсруулах болон хэрэгжилтэнд эрэгтэй эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй оролцож байгаад хяналт тавих

→ Жендэрийн дүн шинжилгээг дараах байдлаар хийнэ:

→ Хөвгүүд болон охид, эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хоорондын боловсролын хэрэгцээ ба боломжийн ялгааг тодорхойлох.

→ Бүтэц ба үйл явцыг тодорхойлох. Жишээ: хууль тогтоомж, нийгэм улс төрийн институтууд, соёлын хэрэгслүүд, сургалтын төвүүд, боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанууд г.м.

→ Хөтөлбөр болон сургуулийн сурах бичгүүд жендэрийн тогтсон үзэл хандлагыг дэмжиж байгаа эсэх дээр дүгнэлт хийх.

→ Мэргэжлийн багш нарын дунд хүйсийн ялгаа байгаа эсэхийг тодорхойлох.

→ Үндэсний болон орон нутгийн түвшинд сургуулийн удирдлагад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох.

→ Санал болгож буй институт ба байгууллагын хүрээг шалгаж өөрчлөлтөнд эмэгтэйчүүдийн оролцооны цар хүрээ мөн төслийн менежментэд тэдний төлөөллийг тодорхойлох.

→ Гол зорилтот бүлгүүдийн ялангуяа ядуучуудын хүртээмж болон оролцоог сайжруулах тал дээр санал болгож буй төслийн нөөц чадавхийг шалгах.

→ ТББ-ууд, үүний дотор эмэгтэйчүүдийн асуудал болон ЖХ-д анхаардаг байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг судлах.

## Эх сурвалжийн түүвэр

Азийн Хөгжлийн Банк 1996. *Ази дахь эмэгтэйчүүдийн боловсрол*. Бүсийн семинарын үйл явцаас, 5 сарын 30-6 сарын 2. Манила, Филиппин улс

Австралийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг.  
1997. *Жендэр болон Хөгжлийн удирдамж*.

Чекчи, Р. 1999. *Орлого болон Боловсролын хүртээмж дэх тэгш бус байдал. Олон улсын харьцуулсан анализ*. Хөгжлийн Эдийн Засаг Судлалын Дэлхийн Институт.

Фильмер, Д. 1999. *Боловсрол дахь Нийгмийн Бүтэц: Жендэр ба Баялаг*. Дэлхийн Банк

UNESCO, 1998. *Жендэрийн мэдрэмжтэй Боловсролын Статистик ба Үзүүлэлтүүд*

АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, 1998.  
*Непал дахь охидуудад Боловсролыг сурталчлах нь*.

---